

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

/2015 оны 2 сарын 04-ны өдрийн байдлаар/


Хүнсний болон өргөн хэрэглээний гол нэрийн барааны дундаж үнийг 2008 оны 5-р сараас эхлэн 7 хоногийн давтамжтайгаар судалж байна.

МАХНЫ ҮНЭ

2015 оны 02 сарын 04-ны өдрийн байдлаар Баруун сайхан, Зүүн сайхан, Хан-уул, худалдааны төвд байрлалтай мах, ногооны захын ханшаар хонины 1 кг мах дунджаар 6000 төгрөгөөр, ямааны мах 5000, адууны мах 5666.7 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонины мах 16.6 хувь, ямааны махны 20.0 хувиар тус тус буурсан байна.

Зураг1.Махны үнэ 2015 оны 1-2 сар


Хонины махны үнэ, 1 кг, төгрөгөөр



Адууны махны үнэ, 1 кг, төгрөгөөр




Ямааны махны үнэ, 1 кг, төгрөгөөр



ГУРИЛ, БУДАА, СҮҮ, ЭЛСЭН ЧИХРИЙН ҮНЭ

2015 оны 2-р сарын 04-ны өдрийн байдлаар малын шингэн сүү худалдаанд зарагдахгүй байна. Харин цагаан будааны үнэ дунджаар 2000 төгрөг, элсэн чихрийн үнэ дунджаар 2000 төгрөг, алтан тариа 1-р гурил 1100 төгрөгөөр худалдаалагдаж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад алтан тариан гурил 12.8, элсэн чихрийн үнэ 5.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин цагаан будааны үнэ өөрчлөлтгүй, тогтвортой байна.


Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, гурилын үнэ, 2015 оны 1-2 сар, төгрөгөөр



АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ҮНЭ

2015 оны 2-р сарын 04-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх газруудын мэдээгээр бензин А-80 дунджаар 1650 төгрөг, бензин АИ-92 дунджаар 1890 төгрөг, дизелийн түлш дунджаар 1910 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 3. Авто бензин, дизелийн түлшний үнэ, 2015 он 1-2 сар, төгрөгөөр



ЯМААНЫ НООЛУУРЫН ҮНЭ

2015 оны 2-р сарын 04-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй түүхий эдийн захад ямааны цагаан ноолуур 54000 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулбал 1.9 хувиар өссөн байна.

Зураг 4. Ямааны ноолуурын үнэ, 2015 он 1-2 сар, төгрөгөөр



Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.